

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 70432545

цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа.....	12
4.2 Албан шаардлага	
4.3 Зөвлөмж	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ХОНТСА	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЖАРГАЛАНТ СУМЫН 3-Р ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.ГАНЦЭЦЭГ ТАНАА

2022.02.21 № 02/46
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР



821.02.0232

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,380,569.00</u>	<u>31,570,864.00</u>
33	АВЛАГА	19,940.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	19,940.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	31,360,629.00	31,570,864.00
351	Түүхий эд материал	544,959.00	575,442.00
35130	Эм боох материал	544,959.00	575,442.00
354	Хангамжийн материал	30,815,670.00	30,995,422.00
35410	Бичиг хэргийн материал	40,000.00	40,000.00
35420	Аж ахуйн материал	176,000.00	-
35430	Сэлбэг хэрэгсэл	3,290,000.00	1,890,000.00
35450	Барилгын засварын материал	1,631,350.00	2,006,350.00
35460	Хүнсний материал	1,360,451.00	2,171,253.00
35470	Бусад хангамжийн материал	24,317,869.00	24,887,819.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>678,347,671.85</u>	<u>647,316,013.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	678,347,671.85	647,316,013.96
392	Биет хөрөнгө	623,961,971.89	593,044,563.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	630,447,058.95	631,647,058.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,496,055.59)	(77,190,083.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,109,369.00	43,759,269.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,516,206.83)	(32,127,588.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,957,290.32	41,257,290.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,642,101.42)	(21,246,482.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,417,651.00	10,417,651.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,315,033.54)	(3,472,550.30)
393	Биет бус хөрөнгө	54,385,699.96	54,271,450.00
39301	Програм хангамж	457,000.00	457,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(228,500.04)	(342,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	54,157,200.00	54,157,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>709,728,240.85</u>	<u>678,886,877.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>37,232.44</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37,232.44	-
413	Өглөг	37,232.44	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	37,232.44	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>709,691,008.41</u>	<u>678,886,877.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	709,691,008.41	678,886,877.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	222,076,478.00	222,076,478.00
51101	Өмч: - төрийн	222,076,478.00	222,076,478.00
512	Хуримтлагдсан үр дүн	300,397,681.11	269,593,550.66
51210	Өмнөх үеийн үр дүн	300,397,681.11	299,803,681.02
51220	Тайлант үеийн үр дүн	-	(30,210,130.36)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	187,216,849.30	187,216,849.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>709,728,240.85</u>	<u>678,886,877.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	512,928,800.00	503,299,470.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,411,500.00	3,022,955.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,011,500.00	523,055.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,011,500.00	523,055.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,011,500.00	523,055.00
122	Тусламжийн орлого	1,400,000.00	2,499,900.00
122001	Хандив тусламж /дотоод/	1,400,000.00	2,499,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,517,300.00	500,276,515.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	438,217,300.00	439,683,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	438,217,300.00	439,683,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	19,073,215.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	19,073,215.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,300,000.00	41,519,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	41,519,400.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	50,300,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	524,109,307.04	533,479,600.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	524,109,307.04	533,479,600.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	490,187,063.23	490,206,798.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,971,638.46	347,901,338.00
210101	Үндсэн цалин	229,773,707.22	238,842,190.00
210102	Нэмэгдэл	86,273,360.24	83,449,794.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,618,200.00
210104	Урамшуулал	23,924,571.00	22,991,154.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,144,693.86	45,621,743.14
210201	Тэтгэврийн даатгал	29,402,414.62	31,750,633.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,441,668.68	3,483,213.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,752,914.94	2,786,570.66
210204	Ажилгүйдлийн даатгал	685,728.48	690,689.72
210205	Эрүүл мэндийн даатгал	6,861,967.14	6,910,635.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,973,671.80	39,256,191.40
210301	Гэрэл, цахилгаан	31,077,705.80	28,561,263.40
210303	Цэвэр, бохир ус	12,895,966.00	10,694,928.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,732,506.75	2,801,517.00
210401	Бичиг хэрэг	1,472,497.00	829,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	265,054.00	370,000.00
210404	Ном, хэвлэл	6,000.00	31,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	333,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	428,550.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	928,955.75	808,867.00
2105	Нормативт зардал	23,431,940.73	13,042,751.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	582,120.00	854,772.00

210502	Хоол, хүнс	21,462,764.98	12,008,679.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,387,055.75	179,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,372,928.20	4,751,300.00
210604	Урсгал засвар	1,372,928.20	4,751,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	626,000.00	674,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,000.00	98,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,933,683.43	36,157,557.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	284,000.00	50,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,649,683.43	36,107,557.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,922,243.81	43,272,802.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,876,248.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,876,248.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,922,243.81	26,396,554.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,922,243.81	26,396,554.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(11,180,507.04)</u>	<u>(30,180,130.24)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	30,000.12
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	30,000.12
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(30,000.12)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(11,180,507.04)</u>	<u>(30,210,130.36)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,076,478.00	188,730,464.77	311,578,188.15	722,385,130.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	222,076,478.00	188,730,464.77	311,578,188.15	722,385,130.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(1,513,615.47)	-	(1,513,615.47)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(11,180,507.04)	(11,180,507.04)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,076,478.00	187,216,849.30	300,397,681.11	709,691,008.41
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	222,076,478.00	187,216,849.30	300,397,681.11	709,691,008.41
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(594,000.09)	(594,000.09)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	222,076,478.00	187,216,849.30	299,803,681.02	709,097,008.32
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(30,210,130.36)	(30,210,130.36)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	222,076,478.00	187,216,849.30	269,593,550.66	678,886,877.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	488,630,659.00	500,276,515.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	488,630,659.00	500,276,515.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	438,217,300.00	439,683,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	438,217,300.00	439,683,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	19,073,215.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	19,073,215.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,300,000.00	41,519,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	41,519,400.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	50,300,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	113,359.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	113,359.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	488,630,659.00	500,276,515.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,630,659.00	500,276,515.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,595,056.19	457,003,712.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,961,744.45	347,971,131.44
210101	Үндсэн цалин	202,885,651.19	231,214,360.00
210102	Нэмэгдэл	108,506,746.01	91,304,440.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,618,200.00
210104	Урамшуулал	23,569,347.25	22,834,131.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,355,270.00	45,569,242.14
210201	Тэтгэврийн даатгал	29,481,570.00	31,698,132.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,468,400.00	3,483,213.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,774,800.00	2,786,570.66
210204	Ажилгүйдлийн даатгал	693,600.00	690,689.72
210205	Эрүүл мэндийн даатгал	6,936,900.00	6,910,635.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,973,671.80	39,757,991.40
210301	Гэрэл, цахилгаан	31,077,705.80	28,561,263.40
210303	Цэвэр, бохир ус	12,895,966.00	11,196,728.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,461,552.00	1,212,467.00
210401	Бичиг хэрэг	919,799.00	109,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,700.00	54,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	265,054.00	89,800.00
210404	Ном, хэвлэл	-	62,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	696,967.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,214,999.00	199,100.00
2105	Нормативт зардал	23,098,186.74	14,009,081.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,164,779.00	565,900.00
210502	Хоол, хүнс	20,447,698.00	12,819,481.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,485,709.74	623,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,765,944.20	3,210,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	700,000.00	-
210604	Урсгал засвар	1,065,944.20	3,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	687,889.00	719,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,889.00	143,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	290,798.00	4,554,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	290,798.00	4,554,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,035,602.81	43,272,802.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,359.00	16,876,248.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	113,359.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	16,876,248.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,922,243.81	26,396,554.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,922,243.81	26,396,554.02
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	489,503,300.00	454,806,745.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	489,503,300.00	454,806,745.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489,503,300.00	454,806,745.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,028,000.00	347,971,131.44
210101	Үндсэн цалин	208,722,000.00	231,214,360.00
210102	Нэмэгдэл	113,941,500.00	91,304,440.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,594,900.00	2,618,200.00
210104	Урамшуулал	22,769,600.00	22,834,131.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,983,800.00	45,569,242.14
210201	Тэтгэврийн даатгал	33,062,700.00	31,698,132.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,480,200.00	3,483,213.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,784,200.00	2,786,570.66
210204	Ажилгүйдлийн даатгал	696,000.00	690,689.72
210205	Эрүүл мэндийн даатгал	6,960,700.00	6,910,635.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,109,400.00	39,757,991.40
210301	Гэрэл, цахилгаан	34,016,100.00	28,561,263.40
210303	Цэвэр, бохир ус	14,093,300.00	11,196,728.00
2104	Хангамж, бараа материалын зардал	515,500.00	515,500.00
210401	Бичиг хэрэг	109,300.00	109,300.00
210402	Тээвэр, шатахуун	54,800.00	54,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	89,800.00	89,800.00
210404	Ном, хэвлэл	62,500.00	62,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	199,100.00	199,100.00
2105	Нормативт зардал	38,769,600.00	14,009,081.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	565,900.00	565,900.00
210502	Хоол, хүнс	37,580,000.00	12,819,481.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	623,700.00	623,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,710,000.00	1,710,000.00
210604	Урсгал засвар	1,710,000.00	1,710,000.00
2107	Томилолт, зочны зардал	113,200.00	
210702	Дотоод албан томилолт	113,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	719,600.00	719,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	143,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,554,200.00	4,554,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,554,200.00	4,554,200.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	489,503,300.00	454,806,745.98
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	489,503,300.00	413,338,754.58
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	439,683,900.00	413,338,754.58
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,819,400.00	41,467,991.40
132001	Орон нутгийн төсвөөс	49,819,400.00	41,467,991.40
3	Төсвийн байгууллага	1	1
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	27
6	Удирдах ажилтан	1	1

7	Гүйцэтгэх ажилтан	16	16
8	Үйлчлэх ажилтан	10	10
15	Төрийн өмчит СӨБ байгууллага	175	67

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,098,700.00	19,073,215.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,098,700.00	19,073,215.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	2,196,967.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	696,967.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	696,967.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,500,000.00
210604	Урсгал засвар	-	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,098,700.00	16,876,248.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,098,700.00	16,876,248.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,638,100.00	16,876,248.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,460,600.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	16,098,700.00	19,073,215.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,098,700.00	19,073,215.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,098,700.00	19,073,215.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Мөнхтулга 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 02 дугаар сарын 20-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын 2 дугаар Цэцэрлэг нь “Хүүхдийн хөгжлийг дэмжих суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” гэсэн зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- *Сургалтын үйл ажиллагааг хүүхдийн онцлог ялгаатай хэрэгцээнд тулгуурлан амжилттай эцэг эх,асран хамгаалагч, олон нийтийн оролцоотой зохион байгуулах,*
- *Хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх,*
- *Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд бага насны хүүхдийн ахиц хөгжлийн түвшинг тодорхойлж хүүхэд бүрийг хөгжүүлэх,*
- *Цахим орчинд өөрийн бэлтгэсэн хичээлүүдийг байршуулах туршлагаа түгээн дэлгэрүүлэх,*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас тус байгууллагад 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын 3 дугаар Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 500.3 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 10.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын 3 дугаар Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30.2 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Авлагын данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31.6 сая төгрөг болж 0.2 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 19.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч үнэ төлбөргүй 0.5 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд бүртгэж 20.1 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 776.5 сая төгрөг байсан бол оны эцэст 781.7 сая төгрөг болж 5.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд 3.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 2.5 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 0.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгасан ба тайлант оны эцэст 647.3 сая төгрөгийн цэвэр үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эцэст өглөгийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 709.1 сая төгрөг байсан оны эцэст 678.9 сая төгрөг болж тайлант онд 30.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 268.1 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 489.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 489.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ховд аймгийн ТЕЗ-аас тус байгууллагын төсвийг 489.5 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 489.5 сая төгрөгийн төсөв баталснаас 439.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 49.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 439.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 41.5 сая төгрөг нийт 481.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 8.3 сая төгрөгөөр дутуу авч урсгал үйл ажиллагаанд 454.8 сая төгрөгийг зарцуулж 26.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 454.8 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.4 сая төгрөгөөр, тогтмол зардлыг 8.3 сая төгрөгөөр нормативт зардлыг 24.7 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 0.1 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар аймгийн БСУГ-аас ариутгалын зардалд 0.7 сая, өвөлжилтийн бэлтгэл хангахад 1.5 сая, ХОНТСА-ны тэтгэмжид 16.9 сая бүгд 19.1 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 111 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, мэдээлэл, 37 мэдээллийг хугацаа хоцроосон мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 14, зарлагын 1 ажил гүйлгээний мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлж, 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 27.0 сая төгрөгийн алдааг залруулж, 3.2 сая төгрөгийн 2 алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Барилга байгууламжийн хуримтлагдсан элэгдлийг 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн мөнгөөр тохируулах бичилт хийгээгүй 26.4 сая төгрөг,

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 27.0 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 02 дугаар сарын 21-ны 5 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

2.2.1 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасан 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг цахим сайтад мэдээлээгүй, хагас жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг байршуулахдаа байгууллагын дарга, нягтлан бодогчийн нарын үсэггүй, е-тайлангаас татаж мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын заалтын дагуу холбогдох мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль хууль, журамд заасны дагуу мэдээллийг үнэн зөв мэдээлж хэвших

4.2.2 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсвийн хөрөнгөөр 3.2 сая төгрөгийн батлагдаагүй хөрөнгө худалдан авсан байгаа нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.4-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу

зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг хэмнэлттэй зарцуулах талаар анхааран ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн	4	30.2	2	27.0			-	-	2	3.2

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР